



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.15 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зэвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, 2020 оны А/445 дугаар тушаалаар батлагдсан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрэм, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Сургалтын хяналтын зөвлөлийн дүрмийг 1, Сургалтын хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба (Б.Солонго)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 11. сарын 29.-ны  
өдрийн 11:30 дүгээр тушаалын  
1 дүгээр хавсралт

1118266548 дк.9128905

## СУРГАЛТЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв (цаашид “Төв” гэх)-ийн Сургалтын хяналтын зөвлөлийн (цаашид “Сургалтын хяналтын зөвлөл” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Сургалтын хяналтын зөвлөл нь үйл ажиллагаандaa Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн шийдвэр болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгоно.

### Хоёр. Сургалтын хяналтын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1 Сургалтын хяналтын зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн нийт 2-5 хүний бүрэлдэхүүнтэй байна

2.2 Сургалтын хяналтын зөвлөлийн даргын түр эзгүйд түүний албан үүргийг нарийн бичгийн дарга орлоно.

### Гурав. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа

3.1 Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь төвийн сургалттай холбоотой асуудалд хяналт үнэлгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргах,

3.2 Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, хурлыг зохион байгуулахтай холбогдох зардлыг сургалтын төсөвт тусгаж төвийн Удирдлагын зөвлөлийн шийдвэрээр олгоно.

### Дөрөв. Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

#### 4.1 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүний эрх

4.1.1 Сургалтын хяналтын зөвлөлөөр асуудал хэлэлцүүлэх, хэлэлцэж байгаа асуудлыг хянах, комиссын бүрэлдэхүүнд ажиллах, үнэлэлт, дүгнэлт өгөх,

4.1.2 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүнээс татгалзах,

#### 4.2 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүний үүрэг

4.2.1 Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд биөчлэн оролцох, санал өгөх,

4.2.2 Хүндэтгэх шалтгаанаар үйл ажиллагаанд оролцох боломжгүй бол Сургалтын хяналтын зөвлөлийн дарга эсвэл нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх,

4.2.3 Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлэх,

4.2.4 Нарийн бичгийн дарга нь Сургалтын хяналтын зөвлөлийн хяналт үнэлгээ, төлөвлөгөөт ажлын явц, хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж, ажлын төлөвлөгөө, тайланг боловсруулан хэлэлцүүлэх, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны бэлтгэлийг хангах, шийдвэрийг зохицуулан хэрэгжүүлэх, шаардлагатай бол зохих шийдвэрийг гаргуулж байх үүргийг хүлээнэ.

#### **Тав. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа**

5.1 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд түүнээс дээш удаа сургалтад хяналт, үнэлгээ хийнэ.

5.2 Хяналт, үнэлгээ хийхээс 7 хоногийн өмнө ЭШМТА-д мэдэгдэнэ.

5.3 Хяналт, үнэлгээ хийсэн протокол, тайлан, санал, зөвлөмжийг ЭШМТА-д хүргүүлнэ.

5.4 Санал, зөвлөмжид үндэслэн залруулах ажиллагааг ЭШМТА гүйцэтгэнэ.

5.5 Сургалтын хяналтын зөвлөлийн хийсэн хяналт үнэлгээний протокол, тайлан зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажуулна.

#### **Зургаа. Бусад**

6.1. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан, алдаа дутагдалтай асуудал, гомдол, саналыг Зөвлөлийн хурлаар, шаардлагатай үед төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.2. Бусад тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны ... сарын ... - ны  
өдрийн ... дүгээр тушаалын  
2 дугаар хавсралт

1118266548 9128905

## Сургалтын хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн

**Сургалтын хяналтын зөвлөлийн дарга:** Б.Солонго, ЭШМТА-ны дарга

**Гишүүд:** М.Цэрэндэжид, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч

Я.Тогтохням, Хүний нөөц, хуулийн зөвлөх

Э.Чагцалдулам, Чанарын менежер, халдварт судлаач эмч

**Нарийн бичгийн дарга:** Э.Тунгалагтуяа, Дотоод аудитор